



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreatkhural@parliament.mn  
http://www.parliament.mn

2022.11.17 № 51

Нүүрс олборлолт, тээвэрлэлтийн  
талаар асуулга тавих тухай

Монгол Улсын Ерөнхий сайд Та 2021 оны 7 дугаар сард "Авлигатай тэмцэнэ гэдэг бол бид өөрөө өөрсөдтэйгөө, мөн намынхаа журмын нөхөдтэйгөө тэмцэнэ гэсэн үг" хэмээн мэдэгдэж, Засгийн газрын ээлжит бус хуралдаанаас авлига, хүнд суртлыг таслан зогсоож, авлигын индексийг бууруулах зорилго бүхий ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатараар даргалуулан байгуулснаа зарлаж байсан.

Мөн 2022 оны 4 дүгээр сард "...Эрдэнэс Монгол" ХХК-тай холбоотой асуудлыг гаргаж тавихаар төлөвлөж байна, нуугаад яах вэ. Маш олон охин компанитай, тус бүр дээр ТУЗ-үүдтэй. Тэнд төрөөс гадуур, хяналтгүй их хэмжээний мөнгө эргэж байгаа. Тавантолгой дээр өнөөдрийг хүртэл сүүлийн 17-20 жилийн хугацаанд аман дээрээс 60 орчим ам.доллараар ачигдаад, хилийн цаана 120-180 ам.доллар болгодог. Энэ дундах 60-70 долларын зөрүүг завшиж байсан бүлэглэлийг илрүүлэх ажлын хэсэг байгуулсан. Энэ талд эдийн засаг цэгцрэхэд манай улсын ДНБ-ий хэмжээ хоёр дахин тэлэхээр байгаа..." гэж мэдэгдсэн.

2022 оны 10 дугаар сарын 5-ны өдөр "Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 362 дугаар тогтоол батлагдаж, уг тогтоолын 2.2-т "Төлбөрийг ашигт малтмал, түүхий эдээр төлөх нөхцөлтэй /off-take/ болон төлбөрийг урьдчилан авч ашигласан гэрээний дагуу, эсхүл төлбөр нь нэн даруй хийгдэх ашигт малтмалын экспортыг валютын бодит орох урсгалыг нэмэгдүүлэхээр оновчтой зохион байгуулах;" 2.3-т "Ашигт малтмалын борлуулалт, хөрөнгө оруулалт, худалдан авалттай холбоотой албаны болон байгууллагын нууцад хамааралтай гэрээ, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг 2022 оны 11 дүгээр сард багтаан нууцаас гаргаж, ил тод болгох арга хэмжээ авах, цаашид нууц гэрээ байгуулахгүй байх." гэж тусгажээ. Улмаар 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар "Эрдэнэс Тавантолгой" ХХК-д онцгой дэглэм тогтоож, Бүрэн эрхт төлөөлөгч томилон ажиллуулах шийдвэр гаргасан.

Засгийн газрын дээрх шийдвэрүүдтэй холбоотойгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр тодорхой хэлэлцүүлгүүд өрнөж, зарим ноцтой мэдээллүүд түгээгдэж, иргэд, байгууллагын зүгээс надтай биечлэн уулзаж, мэдээлэл өгсөн ба үүний дотор Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Засгийн газрын үйл ажиллагаа

2022000135



болон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Монгол Улсын Их Хурал, түүний гишүүдэд урьд өмнө мэдэгдэж байгаагүй олон ноцтой үйлдэл, үйл ажиллагааны талаарх мэдээллүүд багтаж байна. Тухайлбал,

- төлбөрийг ашигт малтмал, түүхий эдээр төлөх нөхцөлтэй /off-take/ болон төлбөрийг урьдчилан авч ашигласан гэрээнүүдийг албаны болон байгууллагын нууцын зэрэглэлтэйгээр байгуулж, орсон орлогыг төсвийн гадуур Улсын Их Хурал, Засгийн газрын хяналтгүйгээр төсвийн шинжтэй хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх байдлаар зарцуулсан тухай;

- 2021 оны дундуур КОВИД-19 цар тахлын хорио цээрийн дэглэмийн улмаас боомтын асуудал хүндэрсэн, коксжих нүүрсний үнэ дэлхийн зах зээл дээр өссөн үеэр нэг тонн нүүрсийг 400 хүртэл ам.доллараар тээвэрлэж байсан тухай;

- "Эрдэнэс Тавантолгой" ХХК-ын гүйцэтгэх захирал асан Б.Ганхуяг хэвлэлд өгсөн ярилцлагадаа "...2022 онд гарсан нийт нүүрсний 670 мянган тонн буюу 11-13 хувийг оффтэйк гэрээнд өгсөн." гэж мэдэгдсэн;

- Нүүрс тээвэрлэж хилээр гарсан автомашиныг хоосон гарсан мэт гаалийн бүрдүүлэлт хийсэн байж болзошгүй асуудал, магадгүй энэ байдалтай холбоотойгоор Монгол Улсын хилээр гарсан болон БНХАУ-ын манай улсаас импортолсон нүүрсний хэмжээний талаарх мэдээллүүдийн хооронд олон сая тоннын зөрүү гарсан тухай;

- Нүүрс тээвэрлэлт, ялангуяа "богинын" гэх Цагаан хад - Гашуунсухайт - Ганц мод боомтын 30 км замын тээвэрт тодорхой улстөрчид, тэдгээрийн хамаарал бүхий аж ахуйн нэгжүүд оролцдог тухай, уг тээвэрлэлттэй холбоотой их хэмжээний авилга, албан тушаалын гэмт хэрэг, хууль бус бэлэн мөнгөний гүйлгээ, түүнийг улсын хилээр нэвтрүүлдэг "гаальтай" гэх тодотгол бүхий суудлын автомашинууд байдаг тухай, ийнхүү оруулж ирсэн хууль бус бэлэн мөнгийг угаадаг, хууль ёсны болгодог сүлжээ үүссэн байж болзошгүй тухай гэх мэтийг дурдаж болох юм.

Транспаренси интернэйшнл байгууллагын гаргасан "Авлигын төсөөллийн индексийн 2021" тайланд Монгол Улс сүүлийн гурван жил 35 оноо авч, 180 улсаас 110 дугаар байрт эрэмбэлэгджээ. Хэдхэн хоногийн өмнө Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль батлагдах үеэр төсвийн хүндрэл, өрийн дарамт, эдийн засгийн хүндрэлийн асуудлууд хурцаар хөндөгдсөн билээ. Гэтэл уул уурхайн баялагийн экспортын голыг бүрдүүлдэг нүүрсний олборлолт, борлуулалт, тээвэрлэлттэй холбогдсон маш олон сөрөг асуудлууд үүсэж, удтал шийдэгдэхгүй, ил тод бус, хяналтгүй болсноос Монголын ард түмний баялаг үнэгүйдэх, түүнээс олсон орлого нь улсын эдийн засгийг хөгжүүлэх, төсвийн орлогыг бүрдүүлэхэд бус, авлига, албан тушаалын гэмт хэрэгтнүүдэд ашиглагдан завшигдахад хүрсэн байж болзошгүй эргэлзээг үүсгээд байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 13 дугаар зүйлийг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуулгыг тавьж байна: Үүнд:

2022000175



1. "Эрдэнэс Тавантолгой" ХХК-ны үйл ажиллагааны хүрээнд өнөөг хүртэл төлбөрийг ашигт малтмал, түүхий эдээр төлөх нөхцөлтэй /off-take/ болон төлбөрийг урьдчилан авч ашигласан хэдэн гэрээг байгуулсан, тэдгээр гэрээнүүдийг ямар байгууллага, албан тушаалтны шийдвэрээр нууцалсан, уг гэрээг хэрэгжүүлснээр орсон орлогыг хэрхэн зарцуулсан, ирээдүйд тэдгээр гэрээний дагуу хэдий хэмжээний нүүрс нийлүүлэх үүрэг хүлээгээд байгаа эсэх;

2. 2020-2022 онуудад Монгол Улсаас нийт хэдэн боомтоор, ямар хэмжээний когсжих нүүрсийг гаргасан, когсжих нүүрсийг хэдэн аж ахуйн нэгж ямар хэмжээгээр олборлож, экспортлож, хэдэн аж ахуйн нэгж тээвэрлэж, ямар хэмжээний орлого олсон эсэх;

3. Когсжих нүүрсний дэлхийн болон БНХАУ-ын зах зээл дээрх үнэ ба Монгол Улсаас экспортлох өртөг хоорондын хэт их зөрүүний учир шалтгаан юу болох, энэхүү үнийн зөрүү нь хоёр улсын тодорхой этгээдүүдийн авлига, хууль бус үйл ажиллагааны орлого, татвараас зайлсхийх нөхцлийг бүрдүүлдэг эсэх;

4. Нүүрс тээвэрлэлттэй холбоотой асуудлыг цэгцлэх, тэдгээртэй холбоотой авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулах, холбогдох этгээдүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, гадаад валютын нөөц болон төсвийн орлогыг нүүрсний экспортын орлогоор нэмэгдүүлэх чиглэлд ямар бодлогын шийдэл гарган ажиллаж, ямар үр дүнд хүрсэн болон хүрэх төлөвлөгөөтэй байгаа эсэх;

5. "Эрдэнэс Тавантолгой" ХХК-ний зүгээс Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төслүүдэд ямар хэлбэрээр, ямар хэмжээний санхүүжилт гарган оролцсон болон эдгээр төмөр замуудын 1 км тутмыг ямар өртөгөөр барьж байгуулсан тухай зэрэг асуудал хамаарна.

Асуулгын хариуг энэ оны 11 дүгээр сард багтаан ирүүлж, төрийн болон албаны, түүнчлэн байгууллагын нууцтай холбоотой асуудал хөндөгдөх тохиолдолд Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн гишүүдийг байлцуулан, Улсын Их Хурлын чуулганы хаалттай хуралдаанд танилцуулга хийнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Г.ДОРЖХАНД

2022000125